



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 08 сарын 12 өдөр

Дугаар А/155

Алтай хот

Г Захирамжид өөрчлөлт оруулах тухай Г

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3 дахь хэсэг, 32 дугаар зүйлийн 32.7 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 02-ны өдрийн А/134 дугаартай Дэлгэр сумын Гуулин тосгоны тохижилт, гэрэлтүүлгийн ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлын үнэлгээний хорооны захирамжийн 1 дүгээр хэсэгт “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Алтангэрэл -Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн” гэснийг “Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга: Г.Болор-Эрдэнэ -“Орон нутгийн өмчийн газрын худалдан авах ажиллагаа хариуцсан мэргэжилтэн” мөн “Үнэлгээний хорооны гишүүн: Б.Батбаатар -Есөнбулаг сумын иргэн” гэснийг “Ч.Ууганбаяр -Есөнбулаг сумын иргэн” болгон тус тус өөрчилсүгэй.

2. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хуульд нийцүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулж, үр дүнг танилцуулахыг үнэлгээний хороо (С.Байгальмаа)-нд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ

Ж.ГАНБАТ

